



Монгол Улсын
Үндэсний статистикийн
хороо

“Ардчилсан засаглал судалгаа”-ны 2009-2017 оны үр дүн

УЛААНБААТАР 2018

Агуулга

БҮЛЭГ I. УДИРТГАЛ	3
1.1 Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл	3
1.2 Судалгааны зорилго, ач холбогдол	3
1.3 Судалгааны арга зүй	3
БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	4
2.1 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ	4
2.2 Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ	8
2.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн хариулт, ажиглалтаар	14

БҮЛЭГ I. УДИРТГАЛ

1.1 Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13-р тогтоолд “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан мэдээллийн санг улсын хэмжээнд бий болгохыг Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст тухайн үед үүрэг болгосон.

МХЗ-9-ийн 3 шалгуур үзүүлэлтүүд нь олон нийтийн үнэлгээний үзүүлэлтүүд байгаа бөгөөд олон улсын туршлага, санаачлагыг харгалзан ҮСХ-ноос тогтмол зохион байгуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” (ӨНЭЗС)-ны хавсралт /модул/ судалгаагаар цуглуулахаар тогтож, ҮСХ-ны даргын 2008 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 10/100 тоот тушаалаар судалгааны үзэл баримтлалыг баталсан.

1.2 Судалгааны зорилго

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хүрээнд дэвшүүлсэн “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг иргэдийн үнэлгээнд суурилан улс, бүс нутгийн түвшинд тодорхойлоход судалгааны үндсэн зорилго оршино.

1.3 Судалгааны арга зүй

Судалгааны түүвэрлэлт нь ӨНЭЗС-ны түүвэрлэлтэд үндэслэн хийгдсэн дэд түүвэрлэлт бөгөөд түүврийн хэмжээ нь судалгаанд хамрагдсан өрхүүдийн гуравны нэг буюу улиралд 936 өрх, жилдээ 3744 өрхийн насанд хүрсэн нэг гишүүн байсан.

Судалгаанд хамрагдах хүнийг ӨНЭЗС-нд хамрагдсан өрхийн гишүүдийн жагсаалтаас санамсаргүй тооны хүснэгт ашиглан сонгосон.

БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

“Ардчилсан засаглал” судалгааг 2008 оны III улирлаас эхлэн явуулж байна. Энэ удаа 2009- 2017 оны судалгааны үр дүнг харьцуулан танилцуулж байна.

2.1 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ

Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө нь хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, санхүү, эдийн засгийн хувьд хараат бус байдал хангагдсан эсэхээр илэрхийлэгдэнэ. Энэхүү хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээг 0-100 хүртэлх оноонд шилжүүлж Зураг 2.1-т харууллаа. Оноо нь бага байх тутам хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг гэдэгтэй иргэд санал нийлэхгүй байна гэж үзэх бөгөөд оноо нь 100-д ойртох тутам санал нийлж байна гэсэн үг юм.


Зураг 2.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдалд өгсөн иргэдийн үнэлгээ, оноогоор, 2009-2017 он



Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, улс төрөөс хараат бус байдаг гэдэгт өгсөн иргэдийн үнэлгээ 2017 оны судалгааны дүнгээр 20.8 болж, өмнөх оноос 2.7 оноогоор, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг гэдэгт өгсөн иргэдийн үнэлгээ 19.9 болж, өмнөх оноос 0.3 оноогоор, Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг гэдэгт өгсөн иргэдийн үнэлгээ 50.2 болж, өмнөх оноос 2.8 оноогоор тус тус өсжээ /Зураг 2.1/.


Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдалд өгсөн иргэдийн үнэлгээг авч үзвэл, 2017 онд нийт иргэдийн 29 хувь нь мэдэхгүй, 26 хувь нь санал нийлдэггүй, 27 хувь нь дунд зэрэг, 9 хувь нь санал огт нийлдэггүй, 7 хувь нь санал нийлдэг, 2 хувь нь санал бүрэн нийлдэг гэж хариулжээ. Үүнийг 2009 онтой харьцуулвал огт нийлдэггүй нь 1.4, санал нийлдэггүй нь 4.9, санал нийлдэг нь 6.6 пунктаар буурч, санал бүрэн нийлдэг нь 1.1, дунд зэрэг нь 4.5, мэдэхгүй гэж хариулсан нь 7.3 пунктаар тус тус өсжээ /Зураг 2.2/.

Зураг 2.2. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2009, 2017 он



Хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 0-100 хүртлэх оноонд шилжүүлж Зураг 2.3-т харууллаа. Иргэд олон нийтийн мэдээллийн байгууллагаас Монголын Үндэсний олон нийтийн телевизэд хамгийн их итгэл хүлээлгэж байсан бөгөөд 2010 онд хамгийн өндөр буюу 95.5 оноотой байсан бол 2016 онд үнэлгээ нь 87.5 болж буурсан байна. Монголын Үндэсний радиод хүлээлгэж байгаа иргэдийн итгэлийг авч үзвэл 2009 онд хамгийн өндөр буюу 92.7 оноотой байсан бол 2016 онд 78.1 болж буурсан байна. Харин шар хэвлэлд хүлээлгэж байгаа иргэдийн итгэл хамгийн бага байна. Шар хэвлэлийн хувьд хамгийн өндөр нь 2013 онд 41.6 гэсэн оноотой байсан /Зураг 2.3/.


Зураг 2.3. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, оноогоор, 2009-2017 он




Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ 2017 оны судалгааны дүнгээр 78.4 болж, өмнөх оноос 0.2 оноогоор нэмэгдсэн байна /Зураг 2.4/.

Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээг авч үзвэл маш муу гэсэн хариулт 2.4 хувь болж, өмнөх оноос 0.5 пунктаар, дунд зэрэг гэсэн хариулт 32.9 хувь болж өмнөх оноос 1.2 пунктаар, сайн гэсэн хариулт 39.2 хувь болж өмнөх оноосоо 0.1 пунктаар, маш сайн гэсэн хариулт 5.0 хувь болж өмнөх оноос 0.7 пунктаар буурч, муу гэсэн хариулт 9.7 хувь болж өмнөх оноосоо 0.1 пунктаар, мэдэхгүй гэсэн хариулт 10.8 хувь болж өмнөх оноос 2.5 пунктаар өсжээ /Зураг 2.5/.

Зураг 2.4. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээ, оноогоор, 2009-2017 он



Зураг 2.5. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2009-2017 он










2.2 Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ

Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөллийг 0-100 хүртлэх оноонд шилжүүлж Зураг 2.6-д харууллаа.

Төрийн дээд байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээг 2017 оны судалгааны дүнгээр авч үзвэл, Ерөнхийлөгчийнх 49 оноо болж өмнөх оноос 15 оноогоор, Засгийн газрынх 37 оноо болж өмнөх оноос 12 оноогоор, Улсын их хурлынх 33 оноо болж өмнөх оноос 12 оноогоор тус тус өсжээ. Цагдаагийн байгууллагуудын хувьд авч үзвэл, замын цагдаагийнх 83 оноо болж өмнөх оноос 3 оноогоор, хэв журмын цагдаагийнх 80 оноо болж өмнөх оноос 1 оноогоор, эрүүгийн цагдаагийнх 79 оноо болж өмнөх оноос 2 оноогоор өсжээ. Харин сургуулиудын хувьд авч үзвэл, улсын сургуулийнх 88 оноо болж өмнөх оноосоо 1 оноогоор өсөж, хувийн сургуулийнх 85 оноо болж өмнөх оноос 2 оноогоор буурчээ.


Зураг 2.6. Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээ, оноогоор, 2009-2017 он






Төрийн эрх барих дээд байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2017 оны судалгааны дүнгээр авч үзвэл Ерөнхийлөгчийнх 44 оноо болж өмнөх оноос 14 оноогоор, Засгийн газрынх 33 оноо болж өмнөх оноос 10 оноогоор, Улсын их хурлынх 30 оноо болж өмнөх оноос 7 оноогоор өсжээ.

Зураг 2.7. Төрийн эрх барих дээд байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, оноогоор, 2009-2017 он




Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2009-2017 оноор авч үзвэл Ерөнхийлөгчид итгэдэг иргэдийн эзлэх хувь 47.5-20.6, бүрэн итгэдэг иргэдийнх 5.7-2.1 хувь болж буурсан бол итгэдэггүй иргэдийнх 10.5-22.4 хувь, дунд зэрэг итгэдэг иргэдийнх 29.0-39.7 хувь, мэдэхгүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 4.8-8.7 болж өссөн байна.

Зураг 2.8. Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2009, 2012, 2017 он




Зураг 2.9. Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2009-2017 он




Улсын их хуралд итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2009-2017 оноор авч үзвэл, итгэдэг иргэдийн эзлэх хувь 29.0-13.5 болж буурсан бол итгэдэггүй иргэдийнх 20.9-27.8 хувь, дунд зэрэг итгэдэг иргэдийнх 40.0-41.7 хувь, бүрэн итгэдэг иргэдийнх 1.3-1.7 хувь, мэдэхгүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь, 3.7-8.0 болж өссөн байна.

Зураг 2.10. УИХ-д итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2009, 2012, 2017 он




Зураг 2.11. УИХ-д итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2009-2017 он




Засгийн газарт итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2009-2017 оноор авч үзвэл, итгэдэг иргэдийн эзлэх хувь 36.1-14.5, бүрэн итгэдэг иргэдийнх 2.2-1.7 хувь болж буурсан бол огт итгэдэггүй иргэдийнх 2.9-6.6 хувь, итгэдэггүй иргэдийнх 14.7-26.2 хувь, дунд зэрэг итгэдэг иргэдийнх 39.6-42.0 хувь, мэдэхгүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 4.4-9.0 болж өссөн байна.

Зураг 2.12. ЗГ-т итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дунд эзлэх хувиар, 2009, 2012, 2017 он



Зураг 2.13. ЗГ-т итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дунд эзлэх хувиар, 2009-2017 он




2.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн хариулт, ажиглалтаар

Судалгаанд оролцсон иргэдээс сүүлийн 12 сард төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагаас авсан үйлчилгээг асууж “тийм” гэж хариулсан иргэдээс үйлчилгээ авах үед авлига ажиглагдсан эсэхийг тодруулж асуусан /Зураг 2.14/.

Сүүлийн 12 сард төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхдээ авилга ажиглагдсан гэж хариулсан иргэдийн хувийг авч үзэхэд эмнэлгийн үйлчилгээ авахад хамгийн их авилга ажиглагдсан байна. Чиг хандлагыг авч үзэхэд 2009-2017 онд төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авилга бүхий л түвшинд тогтмол буурсан байна /Зураг 2.14/.

Зураг 2.14. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига байгаа эсэх талаарх иргэдийн хариулт, хувиар, 2009-2017 он



----- оОо -----